

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ



2020
ЖИЛИЙН
ТАЙЛАН

■ БИДНИЙ ТУХАЙ


Үндэсний давхар даатгал ХК нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, валютын гадагшлах урсгалыг бууруулах, олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор 2014 онд байгуулагдсан төрийн өмчит хувьцаат компани юм. Бид өнгөрсөн хугацаанд олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын үйлчилгээг үзүүлэн ажиллахын зэрэгцээ А.М Бэст агентлагийн /A.M Best/ “AA-” болон “А-” үнэлгээтэй дэлхийн шилдэг компаниуд болох SCOR /SCOR/, Ханновер Ре /Hannover Re/, Жи Ай Си Ре /GIC Re/, Тайпинг Ре /Taiping Re/ давхар даатгалын компаниудтай хамтран ажиллаж байна.

■ ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгалын салбарын өсөлт хөгжлийг дэмжинэ.

■ АЛСЫН ХАРАА

Бид Монгол Улсын даатгалын зах зээлийг олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангаж, даатгалын салбарын эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дэмжинэ.



■ ҮНЭТ ЗҮЙЛС

Мэргэшсэн өндөр чадавх

Даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин.

Манлайлал

Цаашдын зорилго зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлэх нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.

Хамтын зүтгэл

Бусадтай хүндэтгэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.


Үнэнч шударга зарчим

Монгол Улсын хууль журмыг чандлан мөрдөж, компанийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.

Ил тод харилцаа холбоо

Мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, шударга, нээлттэй харилцаа холбоо тогтооно.

■ КОМПАНИЙН БҮТЭЦ



■ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

З.Энхболд – Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Сангийн яамны Хууль эрхзүйн газрын дарга

Гишүүд:

П.Дорждагва – Сангийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга

Ц.Болорчулуун – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга

А.Дэмбэрэл – Үндэсний статистикийн хорооны Статистикийн эрдэм шинжилгээ, арга зүйн газрын дарга

П.Эрдэнэбаатар – Монголын даатгалын холбооны удирдах зөвлөлийн дарга

Д.Насанжаргал – Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны удирдах зөвлөлийн гишүүн

Б.Шаравсамбуу – Хараат бус гишүүн

Ц.Түмэнхишиг – Хараат бус гишүүн

Я.Батханд –Хараат бус гишүүн

■ ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

2020 Улаан буудайн индексжүүлсэн даатгалыг орчин үеийн дэвшилтэт технологи дээр үндэслэн боловсруулж, орон даяар амжилттай нэвтрүүллээ.

2019 Азийн давхар даатгалын холбоо, ARS–д бүх гишүүдийн саналаар холбооны гишүүн байгууллагаар элсэв. Дүрмийн санг 5 тэрбум төгрөгөөр, алдагдлаас хамгаалах санг 4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэв. Олон улсын давхар даатгалын трити гэрээг AM Бест агентлагийн АА, А үнэлгээтэй дэлхийн шилдэг компаниуд болох SCOR, GIC Re компаниудтай амжилттай байгуулав. Практикал даатгал ХХК болон Мөнх даатгал ХХК–ийг трити гэрээгээр давхар даатгав.

2018 Засгийн газрын 303 дугаар тогтоолоор Үндэсний давхар даатгал ХК болж үйл ажиллагаагаа өргөтгөлөө. Үндэсний үйлдвэрлэгч “Говь” ХК даатгасан хам даатгалыг факультатив гэрээгээр давхар даатгав.

2017 Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн ассоциацийн хамтын ажиллагаагаар хэрэгжүүлж буй экспортыг дэмжих төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжүүлэгч байгууллагаар ажиллаж эхлэв.

2016 Улаан буудайн тариаланг эрсдлээс хамгаалах “Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал”–ын бүтээгдэхүүнийг боловсруулж нэвтрүүлэв.

2015 Малын индексжүүлсэн даатгалын 10 дахь удаагийн борлуулалтыг бие даан орон даяар амжилттай зохион байгуулав.

2014 Засгийн газрын 280 дугаар тогтоолоор “ХААДД” ХК үүсгэн байгуулагдав.

■ МЭНДЧИЛГЭЭ

Юуны өмнө та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе! 2020 он Монгол Улс төдийгүй дэлхий дахинд КОВИД-19 цар тахалтай нүүр тулж тэмцсэн жил болж өнгөрлөө. Бизнес эрхлэгч аж ахуй нэгж бид бүхэнд тууштай байх, хүчтэй байхын төлөө тэмцсэн хүч сорьсон жил байлаа. Энэ хүнд цаг үед аливаа эрсдэлээс иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд эд хөрөнгө, ашиг орлогоо хамгаалахыг зорьж байна. Харин Даатгал нь эрсдэлийн удирдаж, шаардлагатай үед нийгэм, эдийн засгаа дэмжих санхүүгийн хэрэгсэл юм.

Цар тахлаас үүдэлтэй хямрал улам нэмэгдэж, бидний бизнес болон өдөр тутмын амьдралд эрс өөрчлөлтийг бий болгож, зах зээлийн тогтворгүй байдал, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд хүргээд байна. Үндэсний давхар даатгал ХК нь урьдын адил хүчтэй байж нийт хөрөнгөө 55.2 тэрбум төгрөгт хүргэсэн даатгалын зах зээлийн

15 хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлт нь манай компанийг үйлчлүүлэгчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ баталгаажуулах, хөрөнгийн үнэлгээний богино хугацааны эрсдэлийг тэсвэрлэх боломжийг олгож байна. Улмаар зах зээлийн тогтворгүй нөхцөлд ч бид харилцагч, үйлчлүүлэгчийнхээ хэрэгцээг хангаж чадна гэсэн итгэлийг өгч байна.

Тиймээс бидний нэн тэргүүний зорилт бол өөрийн үйлчлүүлэгчдээ дэмжих, бүтээгдэхүүний төрөлжилтийг нэмэгдүүлэх явдал юм. КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөө нь бидний энэхүү итгэл үнэмшлийг улам бататгаж өөрсдийн үүрэг хариуцлагаа улам бүр ухамсарлан ажиллахыг шаардаж байна.

Компанийн менежментийн багийн хувьд үйлчлүүлэгчид, хувьцаа эзэмшигчидтэйгээ байнгын харилцаатай байж, тэдний бизнесийг эрсдэлээс хамгаалахын төлөө

бүх боломжоо дайчлан ажиллах болно. Бидний алсын хараа, байгууллагын үйл ажиллагааг сонирхогч талуудад нээлттэй шилэн байлгаж, цаашид сайжруулах боломжийг үргэлж эрэн хайж, бий болгож ажиллана гэдгээ та бүхэндээ хэлэхийг хүсч байна. Цаашид ч өөрчлөгдөж буй бизнесийн эрсдэлийн төрөлжилтөнд хурдан хариу өгөх, шинэ сорилтуудыг даван туулах, олон талт байдалд нийцүүлэн ажилтнуудынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэх, байгууллагын хөрөнгө санхүүг бэхжүүлэх замаар Монгол Улсын даатгалын зах зээлийг олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангаж ажиллах болно.

Бидний урдаа тавьсан зорилгыг дэмжиж хамтран ажилладаг байгууллагууд, баялаг бүтээгч харилцагчдадаа ямагт талархаж байдгаа илэрхийлье.

Та бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн өрөөе!

МЕНЕЖМЕНТИЙН БАГ



■ 2020 оны ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Улаан буудайн индексжүүлсэн даатгалыг орчин үеийн дэвшилтэт технологи дээр үндэслэн боловсруулж, орон даяар амжилттай нэвтрүүлж 316 сая 791 мянган төгрөгний нөхөн төлбөрийг олголоо.

Эмчлэхэд их хэмжээний төлбөр шаарддаг хүнд төрлийн 12 өвчлөлийг даатгах Хүнд өвчний даатгалыг боловсруулж, олон улсын “А” үнэлгээтэй Пик Ре компанитай хамтран ажиллаж байна.

Дотоодын даатгалын зах зээлд ил уул уурхайн эрсдэлийг давхар даатгах үйлчилгээг зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан нэвтрүүллээ. Тус үйлчилгээг нэвтрүүлснээр уул уурхайн бүх эрсдэлээс аж ахуйн нэгжүүдийг хамгаалах юм.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гишүүнээр элсэж, бизнес болон бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан хамтран ажиллаж байна.

2020 оны төлөвлөгөөнд тусгагдсан даатгалын хэлбэрүүд болох хөдөө аж ахуйн даатгалууд, гэнэтийн осол, хөрөнгө, ачаа тээвэр, хариуцлага, санхүү, агаарын хөлөг, агаарын хөлгийн хариуцлага, барилга угсралт, тээврийн хэрэгслийн даатгалд давхар даатгалын үйлчилгээ үзүүлж нийт 3 тэрбум 572 сая төгрөгийн хураамж төвлөрүүллээ.


ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



■ ДАВХАР ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГЫН ХАРЬЦУУЛАЛТ


2019

- МИД
- Газар тариалан
- Бусад даатгалын хэлбэрүүд



2020

- МИД
- Газар тариалан
- Бусад даатгалын хэлбэрүүд



2019

Нийт даатгалын хураамжийн
орлого, 2 тэрбум 074 сая

Бусад даатгалын хэлбэрүүд
431.998 сая/төг


2020

Нийт даатгалын
хураамжийн орлого,
3 тэрбум 572 сая

Бусад даатгалын хэлбэрүүд
1 тэрбум 573 сая/төг

■ МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ

Үндэсний давхар даатгал ХК-ийн зургаадах жилийн МИД-ын борлуулалтын улирал 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр орон даяар эхэлснээс хойш 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд оролцогч даатгагчид болох Ард даатгал ХК, Бодь даатгал ХХК, Монгол даатгал ХК, Монре даатгал ХХК, МИГ даатгал ХХК, Номин даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК, Хаан даатгал ХХК, Мөнх даатгал компаниуд оролцон Хаан болон Төрийн банкаар дамжуулан нийт 28,527 малчин өрхийн малыг даатгалд хамруулж, 3 тэрбум 478 сая төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүллээ. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 16.6 хувийг эзэлж байна.




ХӨДӨӨ АЖ АХУЙН
ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН




28,527

Малчин өрхийн малыг
даатгалд хамруулж, 3
тэрбум 478 сая төгрөгийн
хураамжийн орлогыг
төвлөрүүллээ.



Дээд түвшний эрсдэлийн сан	нийт 934 сая
Дунд түвшний эрсдэлийн сан	нийт 2 тэрбум 930 сая
Хамтын эрсдэлийн сан	нийт 1 тэрбум 927 сая

2020 оны давхар даатгалын хураамжийн орлогоос МИД-ын эрсдэлийн дунд түвшний нөөц санг 173.9 сая, дээд түвшний нөөц санг 35.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж дунд түвшинд 2 тэрбум 995 сая төгрөг, дээд түвшинд 934.3 сая төгрөг нийт 3 тэрбум 930 сая төгрөгийн орлогыг төвлөрүүллээ. МИД-ын дунд болон дээд түвшний эрсдэлийг Олон улсын SKOR /SCOR/ давхар даатгалын компанид даатгуулж 13 тэрбум 101 сая төгрөгийн эрсдэлийг даах чадавхтай боллоо.



Малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоог 2006 оноос хойш харахад давхардсан дүнгээр нийт 230 мянга орчим малчин өрх даатгалд хамрагдсан байна.

■ УЛААН БУУДАЙН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ

Монгол Улс улаан буудайг нийт газар тариалангийн талбайн 70 орчим хувьд тариалдаг. Улаан буудай нь улсын хүнсний аюулгүй байдал, тариалан эрхлэгчдийн ажил эрхлэлтэд ихээхэн нөлөө үзүүлдэг үндэсний стратегийн бүтээгдэхүүн юм. Иймээс Үндэсний давхар даатгал ХК нь Хөдөө аж ахуйг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр Улаан буудайн индексжүүлсэн даатгалыг орчин үеийн дэвшилтэт технологи дээр үндэслэн зохион байгуулж байгаа бөгөөд ХБНГУ-ын Лейбницийн нэрэмжит Шилжилтийн эдийн засагтай орнуудын хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээлэнтэй хамтран бүтээгдэхүүнийг боловсрууллаа.

“Улаан буудайн индексжүүлсэн даатгал гэж даатгуулагчид учирсан бодит хохирол бус даатгалын гэрээний хугацаанд баг (засаг захиргааны нэгж)-ийн хэмжээнд ургамал ургалтын индекс буурсан тохиолдолд нөхөн төлбөр төлөх даатгал юм.” Даатгалын борлуулалтыг Ард даатгал ХХК, Мөнх даатгал ХХК-ийн даатгалын төлөөлөгчдөөр дамжуулан борлуулсан бөгөөд 2020 онд улсын хэмжээнд нийт 387 тариалан эрхлэгчтэй даатгалын гэрээ байгуулж, 15 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 22,488 га талбайд тариалсан улаан буудайг даатгалаа.


Уг даатгалаар тариалан эрхлэгчид ган, хуурай халуун салхи, мөндөр, хортон шавж, хүчтэй салхи, элсэн шуурга, үргэлжилсэн бороо, үер гэх мэт 6, 7 дугаар сарын байгалийн эрсдэлээс хамгаалагдсан бол нэмэлтээр хураамж төлж 8, 9 сарын цочир хүйтрэл, цас, хярууны эрсдэлийг даатгуулсан.

2019

Га талбай – 2,508
Даатгалын үнэлгээ
1 тэрбум 78 сая төгрөг

2018


Га талбай – 782
Даатгалын үнэлгээ
620 сая төгрөг



2020

Га талбай – 22,488
Даатгалын үнэлгээ
15 тэрбум төгрөг

НӨХӨН ТӨЛБӨР



■ МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ

Малын индексжүүлсэн даатгалд 2019 онд малаа даатгуулсан 32,337 малчин өрхөөс Архангай, Булган, Төв, Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Завхан гэсэн 11 аймгийн 51 сум, Улаанбаатар хотын Налайх дүүрэг, нийт 4,036 малчин өрхөд 600 сая төгрөгийн нөхөн төлбөрийг Хамтын эрсдэлийн сангаас олголоо.

■ УЛААН БУУДАЙН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ

Улаан буудайн индексжүүлсэн даатгалд даатгуулсан 387 тариалан эрхлэгчээс нийт 45 аж ахуйн нэгж, иргэн 317 сая төгрөгийн нөхөн төлбөрийг авч байна. Нөхөн төлбөрийн задаргааг даатгалын хариуцлагаар задлан харуулвал:

80%	СКОР 253 сая
10%	ҮДД ХК 32 сая
10%	Ард даатгал ХК, Мөнх даатгал ХХК 32 сая
	45 даатгуулагч

■ МАЛ АМЬТДЫН ДААТГАЛ

Эрчимжүүлсэн мал аж ахуй


100% | ҮДД ХК 17 сая

■ ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийтай хамтран уул уурхайн бус салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор Экспортыг дэмжих төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд “экспортын шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх” нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэгч байгууллагаар Үндэсний давхар даатгал ХК ажиллаж байна. Тус ажлын хүрээнд “Экспортын зээлийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг боловсруулсан. “Экспортын зээлийн даатгал гэдэг нь экспортын гэрээний дагуу төлбөр хийгдэхгүй байх эсвэл гэрээний гүйцэтгэл, цуцлалт зэргээс үүдэн гүйцэтгэлийн зардлыг нөхөж чадахгүй байх эрсдэлээс экспортлогчийг хамгаална.”

■ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ

Экспортын гэрээний дагуу төлбөр хийгдэхгүй байх эсвэл гэрээний гүйцэтгэл, цуцлалт зэргээс үүдэн гүйцэтгэлийн зардлыг нөхөж чадахгүй байх эрсдэлээс экспортлогчийг хамгаална



Даатгах эрсдэлүүд

Арилжааны эрсдэл /Худалдан авагч түр төлбөрийн чадваргүй болох, худалдан авагч дампуурах, төлбөрийн удаашрал/

Улс төрийн эрсдэл /Валютын ханшийн үл хөрвөх байдал, экспорт импортын лиценз цуцлах, дайн, иргэний бослого, үймээн самуун.../





■ ХҮНД ӨВЧНИЙ ЭРСДЭЛИЙН ДААТГАЛ

Монгол Улсын хэмжээнд зөвхөн хавдраар жилдээ 6000 гаруй иргэн өвчилж байгаа ба дийлэнх хувь нь хавдрын III, IV шатанд илрүүлж, өндөр дүнтэй эмчилгээ авах шаардлагатай болж өвчтөн болон ар гэрт нь санхүүгийн хүндрэл үүсдэг. Уг асуудлыг шийдэх зорилгоор хүнд өвчний даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн ба уг бүтээгдэхүүн нь 12 төрлийн хүнд өвчнөөр өвдсөн үед даатгалын үнэлгээтэй тэнцүү хэмжээний нөхөн төлбөрийг эмчилгээний төлбөрт авах боломжтой болох юм.

Хорт хавдар

Бөөрний дутагдал

Титэм судасны мэс засал

Тархины цус харвалт

Эрхтэн ясны чөмөг шилжүүлэх, суулгах

Зүрхний хавхлага солих нээлттэй мэс засал

Хүнд хэлбэрийн түлэгдэлт

Сохрох хараагаа алдах

Цочмог зүрхний шигдээс

Гол судасны мэс засал

Саажилт /үе мөчний үйл ажиллагаа алдагдах/

Тархмал хатуурал /тархи нугасны мэдрэлийн эсийн

гэмтлийн улмаас мэдээ алдах/

Амар даатгал ХХК, Ард даатгал ХК, Практикал даатгал ХХК-уудаар дамжуулан борлуулж байгаа бөгөөд олон улсын давхар даатгалын “А” үнэлгээтэй Пик Ре компанийг давхар даатган ажиллаж байна.

■ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА-2020

Улаан буудайн индексжүүлсэн даатгалын загварчлалыг боловсруулах зорилгоор Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/-ын “Лайбницийн нэрэмжит Шилжилтийн эдийн засагтай орнуудын хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээлэн”-тэй хамтран ажиллах гэрээ байгуулав.

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газрын бүрэлдэхүүн хэсэг болох Английн сансрын агентлагийн санхүүжилттэй “Сибэлиус” төсөлтэй хамтран хиймэл дагуулын мэдээлэлд суурилсан даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж, малчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалан, малчдын амьжиргааг сайжруулах зорилгоор хамтран ажиллаж байна. Олон улсын давхар даатгалын брокер Пинк брокер /PINC/, Жи Би Бода /JB BODA/-тай хамтран ажиллаж, туршлага солилцож байна.

Олон улсын давхар даатгалын трити гэрээг SCOR /SCOR/, Свисс Рэ /Swiss Re/, Жи Ай Си Ре /GIC Re/, Тайпин Ре /Taiping Re/, ПИК РЕ /PEAK RE/ олон улсын давхар даатгалын компаниудтай амжилттай байгуулав. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хамтран хэрэгжүүлж буй Экспортыг дэмжих төслийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжүүлэгч байгууллагаар ажиллаж байна.






Даатгалын хураамж өнгөрсөн жилээс 27 хувь буюу 740 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3 тэрбум 572 сая төгрөгийг хуримтлуулсан байна.




■ САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант онд компанийн хөрөнгө өмнөх оноос 3.589 хувь буюу 2 тэрбум 910 сая төгрөгөөр өсч 55 тэрбум 238 сая төгрөгт хүрсэн нь Монгол Улсын даатгалын салбарын 15 хувийг эзэлж, хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлсэн үзүүлэлттэй байна. Компанийн нийт нөөц сангийн хэмжээ 600 гаруй сая төгрөгөөр нэмэгдэж 25 тэрбум 380 сая төгрөгт хүрч их хэмжээний эрсдэлийг даах чадвартай боллоо.

НИЙТ ХӨРӨНГӨ




ЦЭВЭР АШИГ



ДААТГАЛЫН ХУРААМЖ

сая төгрөг



НӨӨЦ САН



■ ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**“Үндэсний Давхар Даатгал” ХК-ийн
хувьцаа эзэмшигчдэд:**

Дүгнэлт

Бид “Үндэсний Давхар Даатгал” ХК (цаашид “компани” гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид “хураангуй санхүүгийн тайлан” гэх) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бүх тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул “Үндэсний давхар даатгал” ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

**Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд
өгсөн бидний дүгнэлт**

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

**Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий
этгээдүүдийн Санхүүгийн тайланд
хүлээх үүрэг хариуцлага**

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын Аудитын тухай хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.


GRANT THORNTON
AUDIT LLC
Б. ОСОРГАРАВ
УДИРДАХ ПАРТНЕР
Монгол улс, Улаанбаатар хот
2021 оны 1 дүгээр сарын 29
УЛААНБААТАР ХОТ
1118276081 ☎ 2577542


Н. ЭРДЭНЭЦОГ
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

■ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	694,366	1,263,848
Даатгалын авлага	869,051	80,408
Урьдчилж төлсөн зардал болон бусад зарлага	56,393	288,551
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	494,640	1,039,748
Хөрөнгө оруулалт	52,002,143	49,824,266
Үндсэн хөрөнгө	610,754	544,691
Биет бус хөрөнгө	511,468	287,132
Нийт хөрөнгө	55,238,815	53,328,644
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
Өр төлбөр		
Даатгалын өглөг	21,727	386,946
Татварын өглөг	–	1,158,864
Бусад санхүүгийн өр төлбөр	155,861	–
Бусад санхүүгийн бус өр төлбөр	124,465	371,285
Хойшлогдсон татварын өр төлбөр	6,146	–
Орлогд тооцоогүй хураамжийн нөөц	1,195,141	926,610
Хамтын эрсдэлийн сан	1,927,143	1,927,536
Эрсдэлээс хамгаалах сан	4,453,631	3,900,151
Нийт өр төлбөр	7,884,114	8,671,392
Эздийн өмч		
Эзэмшигчдийн өмч	24,500,000	20,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	489,264	489,264
Алдагдлаас хамгаалах сан	19,000,000	19,000,000
Хуримтлагдсан ашиг	3,365,437	5,167,988
	47,354,701	44,657,252
Нийт өмч ба өр төлбөр	55,238,815	53,328,644

■ ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон	2019 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон
Даатгалын хураамжийн нийт орлого	3,572,022	2,074,863
Даатгалын хураамжийн буцаалт	(540)	–
Давхар даатгалын хураамжийн зардал	(1,858,926)	(1,707,969)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	1,712,556	366,894
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	(268,531)	(232,127)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	(545,108)	797,730
Орлогод тооцсон хураамж	898,917	932,497
Нийт нөхөн төлбөрийн зардал	–	(18,450)
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр		
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	(777,075)	(335,934)
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(777,075)	(354,384)
Хөрөнгө оруулалтын орлого	6,208,700	6,065,077
Бусад даатгалын хураамжийн бус орлого	150,550	269,790
Ерөнхий ба удирдлагын зардал	(2,588,710)	(2,510,879)
Санхүүгийн зардал	(32,632)	
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(35,285)	(294,160)
Татвар төлөхийн өмнөх ашиг	3,824,465	4,107,941
Орлогын татварын зардал	(627,016)	(611,840)
Татварын дараах цэвэр ашиг	3,197,449	3,496,101

Улаанбаатар хот-14251, Сүхбаатар
дүүрэг, 1-р хороо, 5-р хороолол 10Б
байр, Бизнес тауэр, 20 давхар

Утасны дугаар: +(976) 7577-002

info@mongolianre.com
www.mongolianre.com